



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
http://www.mojha.gov.mn

2019.12.18 № 4-1/5389
танай 2019.11.29-ны № 10/534 -Т

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА
Ц.ОТГОНБАЯР ТАНАА**

Танай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хэмжээг батлах тухай” 18/14 дүгээр тогтоолыг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 45.6.4 дугаарт бүртгэснийг мэдэгдье.


Ц.НЯМДОРЖ




151695370
Doc.yam a5.2019



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 12 сарын 20-ны
өдрийн 4564 дугаарт бүртгэв.

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 187/14

Номгон

Г Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын
албан татварын хэмжээг тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын "д", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХҮИИ хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хэмжээг хавсралтаар тогтоож, баталсугай.
2. Тогтоосон албан татварыг ногдуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190039

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит
ХҮИИ хуралдааны 18/14 дүгээр тогтоолын хавсралт

**БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ**

Нэг: **Хувиараа зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд**

1.1. Хот хооронд

Утга	Хувь хэмжээ	Төгрөгөөр
Бага оврын автобус /16 хүртэл хүний суудалтай/	5 хувь	21000
Дунд оврын автобус /16-30 хүртэл хүний суудалтай/	7 хувь	29400
Том оврын автобус /31-ээс дээш/	10 хувь	42000

1.2. Сум хооронд

Бага оврын автобус /15 хүртэл хүний суудалтай/	5 хувь	21000
Дунд оврын автобус /16-30 хүртэл хүний суудалтай/	6 хувь	25200
Том оврын автобус /31-ээс дээш/	9 хувь	37800

1.3. Нийтийн тээвэр

Автобус үйлчилгээ	5 хувь	21000
-------------------	--------	-------

Хоёр: **Ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд**

3 тн хүртэл даацтай	5 хувь	21000
3-10 хүртэл тн-ын даацтай	5 хувь	21000
10-40 хүртэл тн-ын даацтай	7 хувь	29400
40-өөс дээш тн-ын даацтай	10 хувь	42000

Гурав: **Ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүнд**

Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн	1 хувь	4200
Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй явуулын худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн	5 хувь	21000